



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/276

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай


Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Бугат багийн Шинэ суурьшлын бүс, хаус хотхон 30 айлын амины орон сууцны зориулалттай “Батдайчин” ХХК /4073886/-ийн эзэмшлийн 6000 метр квадрат газраас 73 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Нямдаваагийн Эрдэнэбаатар /ПД77102078/-д хаягийг Батмонгол 1 дүгээр гудамжны 103 тоот болгон 15 жилийн хугацаагаар шилжүүлэн,үлдсэн 5927 метр квадрат газрыг Батдайчин” ХХК /4073886/-д хаягийг Батмонгол хороолол болгон 14 жилийн хугацаатайгаар тус тус эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ